



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/530

Зуунмод

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6 “а”, “б”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, 2021 оны 259 дүгээр тогтоолоор батлагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын 1, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” албан даалгаврын 4, 5, 6, 9, “Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1, 3.1 дэх заалт мөн аймгийн Онцгой комиссын 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Коронавируст халдварын Дельта хувилбар буюу Мутацлагдсан вирус нийтийн дунд тархах эрсдэлтэй байгаа тул түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглагдах Зуунмод сум руу орох гарах чиглэлийн Өндөр дов, 4 дүгээр зөрлөгийн хяналтын цэгүүд дээр автомат 4 ширхэг хаалт худалдан авах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөсөн хугацаанд дээрх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

3. Шаардагдах зардал 12.320.000 (арван хоёр сая гурван зуун хорин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

1101011000